

Манмин Мэдээ

№ 77 2019 оны 10 сарын 27

“Хүнд хэцүү үед сүмээс маш их хүч болон тайтгарал авсан”



1982он сүм байгуулагдсаны дараа И Жей руг тэргүүн пастор анхны цуглааны элч нар тэмдэг гайхамшигийг үйлдэж, төрөл бүрийн өвчнөөр зовж буй хүмүүст эрх мэдэлт хүчит залбирал хийж өгөхөд тэд өвчнөөсөө эдгэрч, сайн мэдээ тараах төдийгүй хөршөө өөрийн бие мэт хайрласаар ирсэн юм.

Ялангуяа сургалтын төлбөр байхгүйн улмаас сургуульд явж чадахгүй итгэгч байлгахгүйн тулд тусламж, сургалтын тэтгэлэгийн үйл ажилгаа явуулсаар ирсэн. Үүнээс гадна сурагч

хүүхдүүдийн нөхцөл байдалд анхаарч төрөл бүрийн дугуйлан, секц унааны мөнгө, янз бүрийн эрхийн бичгээр дэмжиж сурагч хүүхдүүд хичээлдээ бүх анхаарлаа хандуулахад туслдаг байв.

“Би ахлах сургуулийн 1-р ангиас эхлэн одоо хүртэл И Жей руг тэргүүн пасторын сургалтын тэтгэлэгийг авч байна. Би хөгжмийн их сургуульд ороход гэр нөхцөл байдал мэдэн надад тусласан юм. Одоо би мэргэжлийн төгөлдөр хуурчийн дамжаанд төгөлдөр хуур заалгаж их сургуулийн элсэлтэнд бэлдэж байна” гэж ахлах сургуулийн Ким Бу сог ах

дүү (19) хэлсэн юм.

8-р сарын 18ны Эзэний өдрийн үдээс хойш мөргөлд бага сургуулийн 1хүүхэд, дунд ангийн 15хүүхэд, ахлах ангийн 15хүүхэд, 32оюутан, нийт 73хүүхдэд 2019оны 3-р хагасын сургалтын тэтгэлэгийг гардуулсан юм (Зураг*).

Со Ми жа сүмд үйлчлэгч (Эм, 52) “Тэргүүн пасторын залбирлаар цус багадалт, болон толгойн өвчин, ганцаардлын өвчнөөсөө эдгэрсэн юм. Амьдрал хэцүү байх үед мөнгө, будаа, хачир кимчи хүртэл өгч маш том дэмжлэг болсон ба сүмээс сургалтын тэтгэлэг авч ахлах сургуульд орсон том охин минь их сургуульд орж амжилттай төгсөн сайн ажил төрөлтэй болсон юм” гэсэн юм.

Конго бүгд найрамдах улсаас ирсэн Виржина сүмд үйлчлэгч (Эм, 46) “Солонгост анх ирэхэд ажил ч байхгүй бүх зүйл дасал болж чадахгүй байсан ч сүмээс 10гаруй жилийн турш тусалж ирснээр өдийн зэрэгтэй болсон юм” гэж талархаж байгаагаа илэрхийлсэн юм. Одоо сүмдээ бүлгийн ахлагч мөргөлийн цагаар франц хэлний орчуулагчаар үйлчилж байгаа бөгөөд мөн бусад цагаар гадуур Конго улсын соёлын талаар зааж сургаж байна.

Арван настай байхад нь аав нь маш өртэй үлдээн өөрөө нас барж уйтгар цөхрөл дунд байсан Чүэ

ху хёон ахдүү (27) сар болгон хэрэглээний мөнгө, будаа, хачирын тусламж авч хүнд үеийг өнгөрөөсөн юм. Тэрээр “Ахлах сургуулийн 2-р ангид байхдаа өөрт нь зайлшгүй хэрэгтэй байсан нотебүкний тусламж хүртэл аваад аваад маш их баярлаж байлаа. Манмины итгэгч болоогүй бол би одоо байхгүй ч байж магад” гэсэн юм.

Энэ мэт манай сүм ядуу болон эмзэг бүлгийн хөршдөө туслах үйлсэд хичээнгүйлэн зүтгэсэн юм. Сүмд явдаг боломж муутай эрэгтэй эмэгтэй хүүхдүүд, ганцаараа амьдардаг, настай хүмүүс зэрэг хүнд амьдралтай итгэгч нартаа тэтгэмжийн мөнгө, будаа болон хачраар хангамаар ирсэн юм.

2018оны эхний хагасаас эхлэн явагдсан хиймэл шүд болон шүдний эмчилгээнд зориулсан тусламжын ажилагаа нь өндөр настай болон боломж муутай шүдний эмчилгээнд сайн хамрагдаж чадахгүй байгаа 174н итгэгч нарт шүдний эмчилгээ имплант, хиймэл шүдний тусламж үзүүлжээ.

Үүнээс гадна ойр орчмын хороо зэрэг 5н төрийн байгууллага, 2халамжын төвд сар бүр 70шуудай будаа нийлүүлдэг ба түлээ түлш, хайрын кимчи хуваалцах, оршуулгын ажлын дэмжлэг, хорихын үйлчлэл, эрэгтэй эмэгтэй үсчин зэрэг төрөл бүрийн чиглэлээр Эзэний хайрыг дамжуулж байна.

Бурханы үг болон Есүс Христ төвтэй сүм

Владимир Осипов пастор (ОХУ, Санкт-Петербург)

Би Солонгост бууж ирсэн цагаасаа л Бурханы агуу их хайрыг мэдэрсэн юм. Бурханы сүнслэг мэдрэмжийг мэдэрсэн сэтгэл хөдлөм цаг байлаа. Уулзсан итгэгч болгон баяр хөөртэй инээмсэглэн угтаж, хүлээн авч, хайраар үйлчилж өгсөн юм. Энэ жил ч Манмин Зуны цуглаанд оролцохоор гадаадаас маш олон зочид ирсэн бөгөөд яг эртний танилууд шиг байсан гэр бүлийнхэнтэйгээ байгаа мэт байлаа.

Иохан номын 9-р бүлэгт гардаг төрөлхийн сохор хүн “Бурхан нүгэлтнүүдийг сонсдоггүй, харин Бурханаас эмээж, Түүний хүслийн дагуу үйлдэгч хүнийг сонсдогийг бид мэднэ” гэсэн байдаг. Манмины үйлчлэл нь И Жей руг тэргүүн пасторын залбирлаар дамжуулан гайхамшигт эрх мэдэлт хүчний нөлөө илрэн үй олон гэрчлэл гарч байдаг. Есүс “Хүмүүс та нар тэмдэг гайхамшиг үзэхгүй бол ер итгэхгүй гэсэн байдаг” (Иохан 4:48).

Манмин төв сүм нь Бурханы үгийн дагуу заадаг, Эзэний өдрийг ариухнаар сахих ёстой гэж зөв шудрагаар заадаг юм. Эзэний хайраар Бурханы үгийн дагуу сахин үйлдэх, ариун амьдралыг

чухалчилдаг ариун сайн мэдээг заадаг юм. Ийм сургаалийг сонсвол Бурханы зүрх сэтгэл тэр чигтээ дамжуулагдаж, Түүнийг хайрлах болдог ба Бурханы үгийн дагуу амьдрах хүсэл болон хүчтэй болдог.

Ийм ариун сайн мэдээгээр дамжуулан их ивээл авсан учраас би Манминтай эцсээ хүртэл хамт байх болно. Та бүхний залбирал ба хайр ба дэмжлэгээр манай Оросод сайн мэдээний төвүүд бий болж, библийн сургуультай хүртэл болсон юм.

Эзэн дотор хүчирхэг сургаал ба Ариун Сүнсний нөлөө байдаг учраас Манмин үргэлж өргөжин дээшилж, сайн мэдээг бүх дэлхий даяар дамжуулан Бурханы өгсөн үүргийг сайн биелүүлэх болно. Манмин төв сүмийг босгон байгуулсан Бурхандаа талархал алдрыг өргөө.



‘Сүнслэг хайр’ – 7

Хайр бол зохисгүй авирладаггүй

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй. Зохисгүй авирладаггүй, өөрийнхнийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй.”

1 Коринт 13:4-5

И Жей руг тэргүүн пастор

Мено (Manner) болон Етик (Etiquette) ёс зүй гэдэг нь хүний биеэ авч явах байдал, үйлдэл хөдөлгөөн, зан байдал, ёс суртахууныг илэрхийлдэг үг тул сүүлийн үед өргөн хэрэглэгдэх болсон.

Зөв биеэ авч явах болон орчин нөхцөлдөө тохирсон зохицсон үйлдэл харуулж гэмээн зөв бөгөөд сайхан сэтгэгдэл үлдээж чадах юм. Эсрэгээрээ биеэ зөв аятайхан авч явж чадаагүйгээс болж наад захын ёс зүйг үл тоовол эргэн тойрны хүмүүст тавгүйтлийг өгдөг. Ялангуяа хайртай гэдэг мөртлөө бусдад зохисгүй бүдүүлэг хандвал юу болох вэ? Тэгж хэлсэн үг нь сэтгэлд буухад хэцүү байх юм.

Зохисгүй үйлдэл гэдэг нь ‘Хүмүүжилгүй, ёс зүйгүй’ гэсэн утгатай. Мэндлэх, ярилцах ёс зүй зэрэг нь улс орон, цаг үе тухай бүрд ялгаатай байсан ч хүмүүсийн хооронд баримтлах ёстой ёс жаяг болж хадгалагдсан байсан. Санаснаас олон хүн ингэж зохисгүй авир гаргадаг мөртлөө ухаарч чаддаггүй юм. Түүнчлэн бүр ойрхон хүн ийм байдал тохиолдох нь маш элбэг юм. Ямар нэг байдлаар тайван тухтай харьцах гэдэг нь заримдаа ёс зүйгүй үйлдэл гаргах юм уу бүдүүлэг үг хэллэг үйлдлээр харьцаж буй хүндээ хохирол учруулах тохиолдол ч байдаг.

Үнэхээр хайрладаг ийм зохисгүй үйлдэл гаргадаггүй юм. Хэрэв өөрт нь бусдаас онцгой утга учир бүхий үнэтэй эрдэнэс байвал маш их нандигнах байх. Тэгвэл үнэхээр их хайрладаг бол хичнээн эрхэмлэн харьцах бол? Хайргүй сэтгэлээс үүдэлтэй зохисгүй байдлыг томоор хоёр хувааж болох юм. Бурханы өмнө зохисгүй байдал гаргах тохиолдол, хүмүүсийн өмнө зохисгүй байдал юм.

1. Бурханд зохисгүй хандах

Бид эргэн тойрноо харвал Бурханд хайртай гэх хүмүүсийн дунд эцэстээ тэдний үг ба үйлдлийг харвал хайрладаг гэдгээс хол үйлдэл гаргах тохиолдлыг харж болно. Бурханд зохисгүй хандах явдлуудын дундаас хамгийн түрүүнд мөргөлийн цагаар нойрмоглох явдал юм.

Нэг улсын ерөнхийлөгч юм уу байгуулагынхаа

захирлын өмнө нойрмоглох ч бүдүүлэг явдал бол яаж Бурханы өмнө энэ мэт бүдүүлэг авирлаж болох вэ? Мөргөлийн цагаар хажуу хүнтэйгээ ярилцах, өөр юм бодох нь маш зохисгүй явдал юм. Иймэрхүү үйлдэл нь Бурханыг хүндэтгэх сэтгэл ба цайлган байдал дутуу байгааг шууд хэлээд өгч байгаа юм.

Сургаал зааж байгаа нь ч ‘Сургаал ивээл болж чадахгүй байна уу?’ гэж санаа зовнин Ариун Сүнсний бялхал, хөтлөлийг авч чадахгүй байж болох юм. Эцэст нь өөрөө төдийгүй хамтдаа мөргөлд оролцож буй хүмүүст ч хохиролтой юм.

Мөргөлийн үеэр гарч орох ч мөн адил юм. Мэдээж мөргөлийн үйл ажиллагаанд тусладаг учир зайлшгүй шаардлагатай тохиолдол байдаг ч тийм биш бол мөргөл дуусах хүртэл өөрийн суудалдаа сууж сургаалд анхаарлаа хандуулах ёстой юм. Чимээгүй хүндэтгэл эсвэл элч нарын итгэлийн тунхагаар мөргөл эхэлж, адислал болон Эзэний заасан гуйлтаар дуусах хүртэл бүх дараалалын дагуу мөргөлд оролцох ёстой юм. Магтаал болон залбирал, өргөлийн цаг, мэдээлэлд ч анхаарлаа хандуулан чин сэтгэлээсээ мөргөлд оролцох ёстой юм.

Албан ёсны товлот мөргөлөөс гадна магтаалын цуглаан, бүлгийн, эсийн цуглаан зэрэгт ч адилхан сэтгэлээр оролцох ёстой. Чин сэтгэлээсээ мөргөлд оролцохын тулд юуны түрүүнд хоцрохгүй байх ёстой. Бурхан бидийн мөргөлийг авахын тулд үргэлж түрүүлээд биднийг хүлээж байдаг тул бид ч мөргөлийн цагаас өмнө ирж залбирлаар бэлдэх ёс зүйд нийцэх юм.

Үүнээс гадна архи, тамхи хэрэглэсэн үед мөргөлд оролцох, мөргөлийн цагаар гар утсаар оролдох, балчир хүүхдүүд хашгиралдан нааш цааш гүйлдэх, тоглохыг хориглох, мөргөлийн цагаар бохь зажлах, хоол унд идэж уух ч мөн л бүдүүлэг үйлдэл юм.

Түүнчлэн мөргөлд биеэ авч явах байдал ч маш чухал юм. Гэртээ өмсдөг чөлөөтэй хувцастайгаа юмуу хамаагүй хувцаслаж ирэх нь ч бас зохисгүй үйлдлийн нэг юм. Ёслолын хувцас нь бусдыг хүндэлж байгаа утга илэрхийлж буй бас нэгэн соёл юм. Бурханд итгэдэг бол Тэрээр хичнээн эрхэм нандин эрхэм болохыг мэддэг тул

хамгийн цэвэрхэн цэмцгэр дүр төрхтэй орлох ёстой юм.

Мэдээж Лхагва гаригийн мөргөл юм уу Баасан гаригийн оройн мөргөлд шууд ажлаасаа ирэх тохиолдол их байдаг тул ажлын хувцастайгаа ирэх тохиолдол их байдаг ч энэ тохиолдолд Бурханы өмнө зохисгүй байдал гаргасан гэж үзэхгүй юм. Ямар ч байсан мөргөлд оролцохоор ирсэн сэтгэлийн хүлээн авч баярладаг.

Бурхан мөргөл ба залбирлаар дамжуулан хайртай хүүхдүүдтэйгээ харилцахыг хүсдэг. Ялангуяа залбирал нь Бурхантай ярих яриа юм. Магадгүй яаралтай хэрэг гарсан учраас залбирч хүний биед хүрч, залбирлийг нь зогсоох юм уу, хэн нэгэн өөрийг нь дуудаж байгаа учраас шууд залбирлаа зогсоох ч Бурхантай харилцан ярих явдлыг таслах нь зохисгүй явдалд тооцогддог.

Энэ мэт Бурханы өмнө дахин дахин зохисгүй байдал гаргасаар байвал Бурханы өмнө гэмийн хана бий болж, өвчин зовлон, осол аваар, зэрэг төрөл бүрийн асуудалтай учрах эсвэл удаан хугацааны турш залбиралдаа хариулт авахад хэцүү болдог.

2. Сүмийн байр бол ариун Бурханы өргөө

Сүмийн байр бол Бурхан оршдог газар юм (Дуулал II:4). Хуучин гэрээний үед хурлын майхныг тусгаарлаж ариун орон зай болгон, тахилч нар л орох боломжтой ба түүний дотор ариунаас ариун газар гэж мөн тусгаарлаж тэнд зөвхөн тэргүүн тахилч л жилд нэг удаа ордог байсан юм. Өнөө үед Эзэний ивээлээр хэн ч энэ газарт орж, мөргөлд оролцох боломжтой болсон юм. Есүсийн үнэт цусаар бидний гэмийг золиосолж өгсөн учраас юм (Еврей 10:19).

Сүмийн байр нь зөвхөн мөргөл хийдэг газар бус тус байранд дотор байгаа бүх зүйл, гадна хашаа ч гэх мэт бүх орон зай хамаарна. Түүнчлэн сүмийн байрны хаана ч үг яриа, үйлдлээ анхаарах хэрэгтэй юм. Чанга дуугаар маргалдах, ертөнцийн элдэв яриа, хов жив, тоглоом тохуу боломжгүй юм. Сүм дотор буй эд зүйлстэй мөн хамаагүй харьцах, хэрэглэж болохгүй бөгөөд өргөлийн дугтуйг ч хамаагүй зүйлд ашиглаж болохгүй юм.

Түүнчлэн сүм дотор худалдаа наймаа хийх асуудал байж болохгүй явдал юм. Есүс сүмийн хашаанд Бурханд тахил өргөх мал амьтанг зарж буй, мөнгө сольж буй худалдаачдын ширээг нь хөмөрч тэднийг хөөсөн билээ. Тахил өргөх зүйлийг ч ингэж зүгээр өнгөрөөгөөгүй тул өөрийн хэрэгцээнд зориулан худалдах, худалдан авах байж болохгүй явдал юм. Сүмийн хашаан дотор ч ямар нэгэн зах, үзэсгэлэн яармаг базаар худалдаа явуулахыг ч мөн хориглосон юм.

Бурханы өргөөнд байгаа бүх зүйл Бурханы өмнө мөргөл оролцон, Эзэн дотор нөхөрлөдөг тусгай орон зай юм. Сүмд ирээд залбирал хийж, цуглаж байгаа тохиолдолд сүмийн ариун байдлын тухай өчүүхэн ч үл тоомсорлох явдал гарахгүй байх хэрэгтэй бөгөөд Бурханы өргөөг хүсэн тэмүүлдэг бол бүдүүлэг авирлах явдал байхгүй байх ёстой юм.

3. Хүмүүстэй зохисгүй харьцах

1 Иохан 4:20д “Хэрэв хэн нэгэн нь би Бурханыг хайрладаг гэж хэлчихээд, ах дүүгээ үзэн яддаг бол,

тэр хүн худалч. Учир нь харж байгаа ах дүүгээ хайрладаггүй нэгэн, хараагүй Бурханыг хайрлаж чадахгүй шүү дээ” гэсэн байдаг.

Тэгвэл бид өдөр тутмын амьдрал дунд элбэг тохиолдох зохисгүй явдал нь юу байж болох вэ? Энгийнээр бусдын үүднээс бус өөрийн ашиг сонирхолыг хайсаар энэ нь зохисгүй авирлахад хүргэдэг. Шөнө орой болсон хойно утсаар залгах, ажил ихтэй завгүй хүн рүү утсаар залган удаан ярих нь бусдад ямар нэг байдлаар хохирол учруулдаг. Мөн уулзахаар товлосон цагаасаа хоцрох, бусдын гэрт урьдчлан мэдэгдэлгүй гэнэт зочлох ч мөн л зохисгүй үйлдэл юм.

Заримдаа “Гэмгүй сайхан харьцаатай мөртлөө нэгд нэггүй ингэж тоочоод байвал харин эсрэгээр эвгүй биш үү?” гэж бодох үе ч байдаг. Мэдээж бүгдийг чадах хэмжээний гэмгүй сайхан харьцаатай байсан ч хүний сэтгэлийг зуун хувь тооцоолох ойлгоход хэцүү юм. Би л хувьдаа халуун дотноор илэрхийлж харьцаж байна гэдэг ч хүлээн авч буй бусад хүний мэдрэмж өөр байж болох. Тиймээс үргэлж бусдын үүднээс бодох гэж хичээх хэрэгтэй. Ялангуяа ойр дотно, харьцаатай байх тусам зохисгүй байдал гаргахгүй байх тал дээр анхаарах хэрэгтэй юм.

Ойр дотно байдаг гээд үгээ бодолгүй, хамаагүй хандахад шарх өгөх явдал их бөгөөд гэр бүлийн болон дотны найз нөхөддөө зохисгүй авирлана гэдэг нь харин ч эсрэгээрээ бусдаас ч дорд үзсэн явдал болж ч болзошгүй юм. Мөн насаар бага, байр сууриар бага хүнтэй зохисгүй харьцах, дорд үг болон үд тоосон, захирамжилсан хандлагаар тэдэнд тавгүй байдлыг үүсгэдэг. Ялангуяа өнөө үед эцэг эхээ, багшаа, өндөр настан зэрэг зайлшгүй хүндлэж үйлчлэх ёстой хүмүүст чин сэтгэлээсээ үйлчлэх төрх олж харахад хэцүү болсон цаг учраас юм.

Зарим нь цаг үе өөрчлөгдөж байгаа болохоор яах ч аргагүй гэж ярьдаг ч хувиршгүй зүйл гэж бий. Левит номын 19:32д “Буурлын өмнө босон зогсож, настанг дээдлэн, өөрийн Бурханыг хүндэл. Би бол Эзэн” гэсэн байдаг.

Бурханы хүсэл бол хүмүүсийн хооронд ч ёс зүйтэй байх ёстой бөгөөд ертөнцийн хууль журам, дэг ёсийг сайн сахиж зохисгүй явдал гаргахгүй байх ёстой юм. Олон нийтийн газарт ч гэсэн үймээн шуугиан гаргах, шүлсээ хаях, замын хөдөлгөөний дүрмийг зөрчвөл олон хүмүүст бүдүүлэг хандаж буй хэрэг юм. Ертөнцийн гэрэл ба давсний үүргийг гүйцэтгэх христчин хүн бол улам илүү үг ба үйлдэлдээ анхаарах хэрэгтэй юм.

4. Бүх зүйлийн хэмжүүр болсон хайрын хууль

Ихэнх хүмүүс өдөр бүр хэн нэгэнтэй уулзаж, ярилцаж, хамт хооллож, ажиллах зэрэг маш их цагийг тэдэнтэй хамт өнгөрөөдөг. Тэр хэмжээний хүмүүсийн харилцаан дахь бие биенийхээ өмнө сахин ёс зүй байдаг. Гэтэл хүн болгоны сурсан мэдсэн зүйл өөр өөр, улс үндэстэний соёл ахуй байдал ч өөр юм.

Тэгвэл юуг хэмжүүр болгож байж бүдүүлэг үйлдэл гаргахгүй байх вэ? Бидний сэтгэлд байгаа ‘Хайрын хууль’ юм. ‘Хайрын хууль’ гэдэг нь хайрын уг үндэс Бурханы хуулийг хэлж байгаа юм. Бурханы үгийг өөрийн болгож, үйлдэх тусам Христ дотор хүмүүжиж,

зохисгүй үйлдэл гаргадаггүй. Хайрын хуулинд агуулагдсан бас нэгэн утга нь “Халамж” юм. Тас харанхуй шөнө гэрэл барьсан хүн замаар явж байлаа. Өөдөөс ирж яваа тэр хүнийг ажиглахад урд замаа харж чадахгүй хүн байсан юм. Түүнийг хараад хачин санагдаж, тэр хүнээс асуулаа. “Та урдахаа харахгүй байж яагаад гэрэл барьж яваад байгаа юм?” гэтэл тэр хүн “Тантай мөргөлдөхгүй нь тулд юм. Энэ гэрэл бол таны төлөө юм” гэж хариулсан юм.

Халамжид хүний сэтгэлийг хөдөлгөдөг агуу хүч байдаг. Эсрэгээрээ зохисгүй үйлдэл нь бусдыг халамжилж чаддаггүй сэтгэл, хайр байхгүй сэтгэлээс үүдэлтэй юм. Колоссай 3:23д “Та нар юу ч хийсэн,

хүмүүсийн төлөө бус Эзэний төлөө үйлддэг шиг чин сэтгэлээсээ хийгтүн” гэсэн тул үргэлж Эзэнтэй харьцах мэт үйлчлэх сэтгэлээр сүнслэг хайрыг сэтгэлдээ бий болгоцгооё.

Хайрт итгэгч та бүхэн, Үнэхээр Бурханыг хайрладаг хүн бол сүнсээр үнэнээр мөргөлд оролцож, нүдэнд харагдах ах дүүсээ ч хайрлахад Бурхан ерөөл ба шагналаар буцаан төлдөг. Зохисгүй үйлддэггүй сүнс талын хайрыг төгс биелүүлээд олон хүмүүсийг авралын замаар удирдан, мөнхийн тэнгэрийн оронд нар мэт гэрэлтсэн алдар дотор байхыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

1-р сарын эдгэрэл ивээлийн цуглаанд гэрчлэл хийхээр индэр дээр гарч ирсэн итгэгч нар.



“Тархины саажилтаас эдгэрч, тэргэнцэр болон таяггүй алхдаг болсон!”

Мүн Чан жү итгэгч (78нас)

Би удаан хугацааны турш тархины саажилттай байсан ба 2017оны 7-р сард Хятадад тархины судасны нарийсал өвчний улмаас тархины мэс засалд орсон юм. Тэгсэн ч биеийн баруун тал саажилт улам даамжирч, юм ярьж ч мөн босож ч чадахгүй болсон юм.

Солонгост Манмин төв сүмд явдаг охин (Мүн Со ён) ыхоо ятгалгаар, би гэртээ хэвтэрийн байдалтай хагас жилийн турш GCN телевизээр дамжуулан гарах И Жей руг тэргүүн пасторын сургаалийг сонсон бага багаар итгэл сууж байлаа.

2018оны 8-р сард охиныхоо тусламжтайгаар тэргэнцэртэй Солонгост болох Манмин зуны цуглаанд оролцсон юм. Тэргүүн пасторын залбирал хийж өгсөн гар

алчуур (Үйлс 19:11-12) аар номлогч И Сү жин пастор нийт оролцогчид руу хандан залбирал хийж өгөх үед гайхамшигтай зүйл болж саажсан баруун гараа би өргөж чаддаг болсон юм.

Зуны цуглаанд явж ирээд бие маань маш хурдацтай сайжирч байлаа. Манмин залбирлын хүрээлэнгийн цуглаанд оролцоод хоёр өдрийн дараа тэргэнцэрээсээ босч, Здахь өдрөө таяг тулан, алхдаг болсон юм. Мөн баруун гараараа юм бичдэг болж, арай төгс биш ч ярьдаг болсон юм.

Бурханы мутар хүрч буй мэдрэмжийг би 2018оны хоёр хагасын ‘2 удаагийн Онцгой Даниел залбирлийн цаг’ оролцон залбирал хийж, цусны даралт ихдэх, зүрхний шигдээс өвчнөөсөө

эдгэрсэн юм. Илүү талархалтай зүйл нь 2019оны 1-р сарын 17ний өдөр эдгэрэл ивээлийн цуглааныг хүсэн тэмүүлж, мөн Манмин залбирлын цуглаанд оролцож байхад ам муруйж шүлс гоождог байсан маань хэвийн болж эдгэрсэн юм.

Эцэст нь 1-р сарын 25ны баасан гаригын оройн мөргөлийн 2-р хэсгээр болсон эдгэрэл ивээлийн цуглаанд И Сү жин пасторын гар алчуурын залбирал авч, таяггүй удаан алхдаг болсон юм. Халлелүяа!

Насан турш өрөөл биеэр амьдарч ирсэн би энэ мэт дахин алхдаг болгож, цаашид илүү төгс болгож өгөх сайн Гурвын холбооны Бурхандаа бүх талархал ба алдрыг өргөө.

“Хиймэл шүтээн шүтдэг миний нутаг Эзэнд итгэдэг тосгон болсон!”



Моти Чанд сүмд үйлчлэгч (40нас, Энэтхэг, Дели Манмин цуглаан)



Эцэг эхээ эрт алдаж, сургуульд ч сайн явж чадаагүй би өөртөө итгэлгүй, айх зүйл ихтэй нэгэн байлаа. Мөн нурууны архаг өвчтэй байсан юм. Тэгтэл Дели манмин цуглаанд явдаг болоод Дэлгэцээр дамжуулан И Жей руг тэргүүн пасторын залбирлаар нурууны өвчнөөсөө эдгэрч, талархах сэтгэлээр хичээнгүйлэн сайн мэдээ тараахад айдастай бүрэг байдал минь ч арилж, зан ааш минь өөрчлөгдсөн.

Би Бурхантай уулзаад миний бүх амьдрал өөрчлөгдсөн шиг миний төрөлх нутгийнхан маань ч ийм болоосой гэж хүссэн юм. Уттар Прадеш, Горакпур гэдэг тариалангийн бүс нутагт зөвхөн Есүс бидний аврагч Эзэн гэдгийг сонсч чадаагүй газар учраас сэтгэл маш өвдөж, залбирдаг байв.

2018оны 5-р сард хамаатны хурим болоод нутаг руугаа явах болсон юм. Би хамаатныхаа гэрийнхэнд болон тэр хуримд уригдсан хүн болгонд Есүс Христийн тухай дамжуулж, өөрт тохиолдсон зүйлээ хэлж өгсөн юм. Мөн библид тэмдэглэгдсэн хүч нөлөө одоо ч мөн адил гарч байгааг мэдүүлж өгөн тэргүүн пасторын залбирал хийж өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12)-р залбирал хийж өгсөн юм.

Тэгтэл тэр үед гайхамшигтай явдал болов. Сема (35) гэх эмэгтэй биеийн зүүн тал саажилттай ганцаараа алхаж чадахгүй, юу ч хийх боломжгүй байсан ба гар алчуураар залбирал хийж өгөхөд алхдаг болж, зүүн гараа өргөж хөдөлгөдөг болсон юм.

Мөн төрөхөөс эхлэн алхаж чадахгүй Анкуш (3) гэдэг эрэгтэй хүүхдэд залбирал хийж өгсөний дараа алхдаг болсон юм. Үүнээс гадна төрөл бүрийн өвчин хөндүүр эдгэрсэн хүмүүс гэрчлэл хийж үүнийг харсан хүн болгон шахуу Эзэнийг хүлээн авсан юм.

Үүний дараа манай гэр бүл төрсөн нутаг руугаа нүүж очин, эрч хүчтэйгээр Бурханы үгийг дамжуулсан юм. Хэдийгээр энэ газар цуглаан байхгүй ч тосгоны хүмүүс долоо хоног болгон цуглан юүтүбээр ‘GCNTV HINDI’ сувгаар дамжуулан Манмин төв сүмийн мөргөлд оролцон орой бүр даниел залбиралын цагтаа хамт оролцдог.

Өмнө нь маш их хиймэл шүтээнд үйлчилдэг байсан болохоор ямар ч хариулт авч чадалгүй төрөл бүрийн асуудлаар зовж байсан тэр тосгоны хүмүүс тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлын видео болон гар алчуурын залбирлаар дамжуулан эдгэрэл төдийгүй төрөл бүрийн асуудлаасаа ангижирсан юм.

Миний үеэл Анита нь жилийн өмнөөс муу

сүнсэнд эзэмдүүлэн зовж байгаад ‘GCNTV HINDI’-р дамжуулан тэргүүн пасторын сургаалыг сонсч хиймэл шүтээнд үйлчлэх зэрэг тэр хугацаанд хийсэн гэм нүглээ гэмшин, гар алчуурын залбирал авахад Ариун Сүнсний гал бууж муу сүнс зайлсан байдаг. Одоо эрүүл саруул сургуульдаа явж гэрийнхэн нь аз жаргалтай болсон юм.

Мөн Маниш толгойд гарсан хатиг, Росини савны үрэвсэл, Прабу нь шамбарам өвчнөөс, Жанбахадур халууны өвчнөөсөө эдгэрч Бурханы агуу хүч нөлөө илрэн гарч байна. Одоо 50орчим хүн цуглан гэрийн цуглаан болсон хичнээн том ерөөл билээ.

Өчүүхэн юу ч биш миний хувьд Эзэний ивээлээр сайн мэдээ тараах хүртэл удирдаж өгсөн Бурханд бүх талархал өргөө.



УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11:30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09:00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15:00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17:00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан: power3712@gmail.com

“Амийн сүм рүү удирдуулж ерөөлийн нууцыг мэдлээ!”

Би эхнэрийнхээ тасралтгүй сайн мэдээ тараасны эцэст 1992 онд Манмин төв сүмд бүртгүүлсэн билээ. Тэгээд ч буддын шашинтай гэр бүлд төрсөн болохоор Бурханы талаар сайн мэдэхгүй итгэлийн амьдралын утгыг ч ухаараагүй би дөнгөж л Эзэний өдрийн их мөргөлд арай гэж очдог байлаа.

Тэгээд 2000 оны 5-р сар 2 долоо хоногын сэргэлтийн цуглаан д оролцоод И Жей руг тэргүүн пастор зөвхөн индэр дээрээс залбирч өгөхөд алхаж чадахгүй байсан нь алхдаг болж буй хараад Бурханы амьд оршин буйг ухаарч, гэмшихэд аяндаа нулимс гарч байлаа. Үүний дараа Амралтын өлрийг төгс сахих төдийгүй сүмд үүрэг хүлээж аван итгэмжтэйгээр үйлчлэх болсон юм.

2002 онд өөрийн хамаарах бүлгийнхээ гишүүдтэй хамт И Жей руг пасторын урьсан Энэтхэгийн нэгдсэн их цуглаан д оролцож, Зсая гаруй хүн цугларсан их хүмүүсийн эрч хүч, маш олон хүмүүс өвчнөөсөө эдгэрч буй эрх мэдэлт хүчийг хармагцаа илүү ихээр Бурханы амьд оршин буйд бат итгэсэн.

Тэгж байгаад 2004 оны 6-р сарын үед юм. Маш хүчтэйгээр гэдэс хэвлийн баруун талаар өвдөж, эмнэлэгт очтол мухар олгой хагарахын өмнө байдалтай тул шууд хагалгаанд оролх хэрэгтэй гэсэн юм. Гэвч би



Ян Ү юун ахлагч (71 нас, 1-р их бүлэг 5-р хэсэг)

тэргүүн пастор дээр очин тухайн үед миний бизнес хүнд байдалд орж хэдэн зуун саяын алдагдалд орсон гэх шалтгаанаар арваны нэгийн өргөлөө өргөж чадаагүй зэргээ гэмшин залбирал авсан юм. Залбирал дуусч “Амеен” гэх тэр хоромд гайхалтай нь өвчин хөндүүр арилсан юм. Дахин хоол иддэг болж, түүний дараа шинжилгээ өгөхөд цэвэрхэн эдгэрсэн гэдгээ мэдсэн юм.

Ингэж амьд орших Бурхантай уулзсан мэдрэмжээр дамжуулан тэргүүн пастор Бурханыг нэгдүгээрт хайрлан олон хүмүүсийг хайрлаж, эрх мэдэлт хүчийг гуйн, олон хүмүүсийг Эзэний өвөр рүү удирдаж байгаад нь маш талархсан юм.

Түүнээс хойш миний амьдралд шинэ эргэлт болсон юм. Өмнөх шиг өөрийн мэдлэгт түшиглэлгүй тэргүүн пасторын сургаалийн дагуу шударга байдлаар бизнесээ эхлүүлсэн юм.

Шунал, ёс бус байдлыг хаяад бүр анхнаас нь аажмаар өөрийн аж ахуйг эрхэлж эхэлсэн юм. Мөн туслах хүнийг илгээж өгч, их мөнгө орохгүйгээр бизнесээ суртчилах аргыг мэдэж аван Бурханы тусламжтайгаар ерөөлийг авсан юм.

Юу юунаас илүү том ерөөл нь 70 гарсан насандаа өвдөх зүйл огт байхгүй эрүүл энх эрч хүчтэй ажиллаж байгаа учраас хамгийн талархалтай юм.

Эхнэр маань итгэлийн амьдралаар сайн зүтгэж өвдөж эмнэлэг явах шаардлагагүй хамгаалж өгсөн ба зуны цуглааны спорт тэмцээн болгонд надтай хамт бөмбөлөгтэй буухианы тамирчнаар 7 дох жилдээ рөсөлдөж байна.

Амьдралд минь эрүүл энх, үнэ цэнэтэй амьдрах ерөөлийг өгсөн Бурхан Аавдаа бүх талархал ба алдрыг өргөө.

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048
<http://www.manmin.org/english>
www.manminnews.com
e-mail: manminninen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00

